


Биологи

Идэш тэжээлийн хэлхээн дэх хүний нөлөөлөл



Долоодугаар анги



Суралцахуйн зорилт

Б7.4б. Идэш тэжээлийн хэлхээний зүй тогтол алдагдахад хүний үйл ажиллагаа нөлөөлөхийг жишээгээр тайлбарлах

Зорилго



- Идэш тэжээлийн хэлхээнд хүний үзүүлж буй сөрөг нөлөөг илрүүлэх
- Хүрээлэн буй орчинд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох

Идэш тэжээлийн хэлхээн дэх амьд биеийн үүрэг



Бүтээгч амьд бие

- Гол мөрний усны нөөц, урсацыг зохицуулах
- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах
- Хүлэмжийн хийг шингээх
- Хүчилтөрөгчийг ялгаруулах
- Амьтан, ургамал, бичил биетний амьдрах орчин болно.

Хэрэглэгч амьд бие

- Ургамлаас шим бодис, энергийг авна.
- Бусад амьд биеийн хоол тэжээл болж, энергээр хангана.


Задлагч амьд бие

- Мөхсөн ургамал, амьтны үлдэгдлийг задалж байгаль дэлхийг цэвэрлэнэ.
- Бодисыг эргэлтэд оруулна.


Идэш тэжээлийн хэлхээнд хүний үзүүлэх сөрөг нөлөө




Ойн идэш тэжээлийн сүлжээ



Тал хээрийн идэш тэжээлийн хэлхээ



Усны идэш тэжээлийн хэлхээ



Идэш тэжээлийн хэлхээнд хүний үзүүлэх сөрөг нөлөө



Монгол орны ойн тархалт



Vegan Earth Green, NGO, Mongolia

2016 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 8 орчим хувийг ой эзэлж байна.

Идэш тэжээлийн хэлхээнд хүний үзүүлэх сөрөг нөлөө



Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд улсын хэмжээнд 1.4 сая.га-гаар ой мод хорогдсон нь ойн гэр бүл (идэш тэжээлийн хэлхээ, сүлжээ) -д нөлөөлж байна.

А.Хууль бус мод бэлтгэл



Б. Гал түймэр 2019 он

ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭР



91
удаа

Нийслэл, Баян-Өлгий, Булган,
Дархан-Уул, Дорноговь,
Дорнод, Завхан, Сүхбаатар,
Сэлэнгэ, Төв, Хөвсгөл,
Хэнтий аймгийн
50 сум

нийт 305679.4 га

талбай

50305.8 га ой

түймэрт

255373.6 га хээр

өртсөн

В.Уул уурхай



Г. Хөнөөлт шавж



Идэш тэжээлийн хэлхээнд хүний үзүүлэх сөрөг нөлөө



2020 онд Австралид 11 сая га талбай түймэрт шатсаны улмаас 33 хүний амь үрэгдэж, олон мянган хүн орон гэрээ алдаж, хагас тэрбум ан амьтан үхэж үрэгдсэн байна.

Түймэрт 13 зүйл шувуу, 20 зүйл хэвлээр явагч, 5 зүйл сээр нуруугүйтэн, 19 зүйл хөхтөн, 22 зүйл хавч, 17 зүйлийн загасны тоо толгой цөөрчээ.

Мөн нэн ховордсон буюу зүйлсийн тоо толгой нь 30 хүртэл хувиар хорогдсон амьтны 113 зүйлийг нэн тэргүүнд хамгаалах шаардлагатайг зарлажээ. Энэхүү жагсаалтад уутат баавгай, шувууд, загас, мэлхийн төрөл зүйлс багтсан байна.

Дасгал




Ойн түймэр гарснаас хойш 40-100 жилийн дараа өмнөх байдалдаа эргэн очдог.

Австралид гарсан түймэрт 13 зүйл шувуу, 20 зүйл хэвлээр явагч, 5 зүйл сээр нуруугүйтэн, 19 зүйл хөхтөн, 22 зүйл хавч, 17 зүйл загасны тоо толгой цөөрчээ.

1. Түймэрт өртсөн амьтдын зүйлийн тоог ашиглан баганан диаграмм байгуулаарай
2. Баганан диаграммд үндэслэн дүгнэлт бичээрэй.

Дасгал




1. Эдгээр амьд бие оршин байх газаргүй болсон.
2. Идэш тэжээлийн хомсдолд орсон.
3. Идэш тэжээлийн хэлхээний зүй тогтол алдагдсан.
4. Нэн ховордсон амьтан, ургамал устах аюулд өртсөн.



Нийт малын тоо 1970 - 2019




Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо



◆ Малын тоо

Дасгал



1. Малын тоо толгой өсөх нь тал хээрийн ургамалжилтад хэрхэн нөлөөлөх вэ?
2. Ховор, нэн ховор ан амьтдын тоо толгой, тархалтад нөлөөлөх үү? Мэдээлэл цуглуулж, судлаарай.
3. Тал хээрт амьдардаг ховор, нэн ховор ан амьтдын идэш тэжээлийн хэлхээ, сүлжээг бүтээж, асуудал дэвшүүлж ярилцаарай.

Монгол улсын нийт малын тоо 2019 оны байдлаар **70 969 315**

(Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.)

Дасгал




1. Хөрсний үржил шим буурах, ургамлын төрөл, зүйл, тархац нутаг багасна.
2. Идэш тэжээлийн хэлхээ, сүлжээний зүй тогтол алдагдаж, амьтдын шилжилт хөдөлгөөн бий болно.
3. Ховор, нэн ховор зүйлийн тоо толгой буурч, улмаар мөхөлд хүрнэ.

Дасгал



1. Сурагчид хотын ойролцоох голын усны 4 байрлалаас дээж авчээ. Тэдгээр байрлалыг А, Б, В, Г үсгээр тэмдэглэв.



А. Голын урсгалын хүчилтөрөгчийн агууламж бага, бохирдолтой хэсгүүдийг нэрлэж, учрыг тайлбарлана уу.

Б. Усны найрлага болон хүчилтөрөгчийн агууламж ижил байх хэсгүүдийг нэрлэж тайлбарлаарай.

В. Амьдарч буй орон нутгийнхаа ариутгаагүй хаягдал ялгаруулан гол мөрний усыг бохирдуулдаг үйлдвэрийн газруудаас гурвыг нэрлэж, тэдгээрийн хаягдлын хэмжээг бууруулах боломжуудаас дурдана уу.

Дүгнэлт



- Ил задгай гал түлэхгүй, галаа манах
- Өнжмөл өвсийг шатаахгүй байх
- Хог хаягдал шатаахгүй байх
- Ногоон байгууламжийн тайлбайг нэмэгдүүлэх
- Байгаль орчинд халгүй, бохирдол багатай технологийг амьдралд нэвтрүүлэх
- Дэд бүтцийг сайжруулах, зөвшөөрөгдсөн замаар зорчих
- Хэрэглээгээ хянах, хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах

Бид юу хийж чадах вэ?



Даалгавар



“Амьд биеийг хамгаалахад миний оруулах хувь нэмэр” гэсэн сэдэв асуудал дэвшүүлсэн эссэ бичээрэй (үг 300).